

"ГЕРМЕС ЦЕНТР" ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Компанийн тухай

"Гермес центр" ХК нь Баянгол дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт орших газарт барилгын материал, гэр ахуйн захиалгат тавилгын худалдааны төвийн чиглэлээр түрээсийн үйл ажиллагаа явуулдаг.

Манай худалдааны төв нь Улаанбаатар хотын А зэрэглэлийн бүсэд хотын төвд оршдог, дэлхийн нэр хүнд бүхий брэндийн барилгын үндсэн материал, тоног төхөөрөмжүүдийг өргөн сонголттойгоор худалдаалдаг, гадна талбайдаа 100 гаруй автомашины зогсоолтой, 24 цагийн харуул хамгаалалттай, хяналтын камерын иж бүрэн системтэй, контейнер агуулахын хэсэгтэй, түрээслэгчдийн зүгээс худалдан авагчдад бараа материалын хүргэлтийн үйлчилгээ үзүүлдэг Монголын анхдагч барилгын материалын төрөлжсөн их дэлгүүр юм.

Компанийн түүх

"Гермес центр" ХХК нь супермаркет, гадаад худалдаа, түрээсийн үйлчилгээ эрхлэх чиглэлээр хувь нийлүүлэгчдийн хурлын 2003 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 01 тоот тогтоолоор үүсгэн байгуулагдсан бөгөөд 2005 онд барилгын материал, гэр ахуйн тавилгын Худалдааны төвийг шинээр барьж ашиглалтанд оруулсан.

2008 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн хэлбэрийг өөрчлөн хувьцаат компани болох асуудлыг тавьж, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 99 тоот тогтоолоор тус компанийн энгийн хувьцааны тоог 78,543,001 ширхэгээр баталж, нийт энгийн хувьцааны 30 хувь болох 23,562,900 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон Монголын хөрөнгийн биржээр арилжаалах шийдвэр гаргаснаар "Гермес Центр" Хувьцаат компани болсон юм.



2009 онд компани нь удирдлага, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийг хийж, компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлсэн.


2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар "Гермес Центр" ХК нь 16 ажилтан ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж, давхардсан тоогоор 210 гаруй түрээслэгч аж ахуйн нэгж, иргэдтэй түрээсийн гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Санхүүгийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Төгрөг				
		2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
1	Эргэлтийн хөрөнгө	1,336,723,863.51	1,325,128,405.94	1,403,086,689.58	1,541,179,226.10	1,678,326,249.34
2	Эргэлтийн бус хөрөнгө	7,152,144,661.43	7,097,247,925.97	7,035,735,803.31	6,861,584,941.56	6,805,624,589.59
3	Нийт хөрөнгө	8,488,868,524.94	8,488,868,524.94	8,438,822,492.89	8,402,764,167.66	8,483,950,838.93
4	Нийт өр төлбөр	162,184,502.80	216,289,390.23	219,610,530.09	209,455,277.50	198,987,075.45
5	Эзэмшигчдийн өмч	8,326,684,022.14	8,206,086,941.68	8,219,211,962.80	8,193,308,890.16	8,284,963,763.48
6	Борлуулалтын орлого	1,229,671,338.49	1,367,026,698.85	1,494,879,283.52	1,367,696,294.36	1,334,591,010.34
7	Нийт орлого	1,279,679,591.59	1,624,419,855.04	1,569,335,970.52	1,489,906,907.10	1,490,397,917.45
8	Нийт зардал	822,550,056.86	807,978,457.68	830,946,635.87	817,376,753.65	774,988,602.67

9	Нийт ашиг	507,920,708.79	906,223,411.28	820,420,575.30	750,829,448.23	794,898,101.23
10	Цэвэр ашиг	457,129,534.73	816,441,397.36	738,389,334.65	672,530,153.45	715,409,314.78
11	EPS /Нэгж хувьцаанд ногдох ашиг/	5.82	10.39	9.40	8.56	9.11
12	PE /Үнэ ашгийн харьцаа/	28.01	16.35	13.04	19.84	15.59
13	ROE /Хувьцаат капиталын өгөөж/	0.05	0.10	0.09	0.08	0.09
14	BV /Нэгж хувьцаанд ногдох дансны үнийн харьцаа/	1.63	1.70	1.23	1.70	1.42





Хувьцааны ханшийн өөрчлөлт

Компанийн нэгж хувьцаа анх 2008 онд 100 төгрөгөөр арилжаалагдаж байсан бол 2017 онд нэгж хувьцааны ханш 142.04 төгрөг болсон бөгөөд дараах графикаар хувьцааны ханшийн өөрчлөлтийг харуулав.



2017 оны байдлаар нэгж хувьцаа зах зээл дээр 142.04 төгрөгөөр арилжаалагдаж эзэмшигчдийн хөрөнгө 1.4 дахин өссөн байна.


Хувьцааны зах зээлийн үнэлгээ

"Гермес Центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээр 2 дугаар ангиллын компанид багтдаг бөгөөд 2017 оны 12 дугаар сарын байдлаар зах зээлийн үнэлгээ 11.2 тэрбум төгрөг болсон байна.

Ногдол ашгийн өгөөж

"Гермес центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээрх хамгийн идэвхитэй ногдол ашиг тараадаг компаниудын нэгэн бөгөөд хувьцаа эзэмшигчдэдээ 2008 оноос эхлэн ногдол ашиг тарааж ирлээ.

2008-2017 онуудад тараасан ногдол ашгийг дараах графикаар харуулав.



Гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүн

1. Гүйцэтгэх захирал: Б.Оюунцэцэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

1. ТУЗ-ийн дарга: Д.Оюунсүрэн
2. ТУЗ-ийн ердийн гишүүд: Б.Оюунцэцэг
Д. Алтанчимэг
Ц.Түвшинжаргал
Н.Мөнхзул
Б.Амарсанаа
3. ТУЗ-ийн хараат бус гишүүд: Н.Батсайхан
Д.Туяа
Б.Алтангэрэл

"ГЕРМЕС ЦЕНТР" ХК-ИЙН 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Энэ 2018 оны эхний хагас жилд манай компани нь 672.7 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 339.2 сая төгрөгийн зардалтай, татварын байгууллагад 183.5 сая төгрөгийн татвар төлж, 461.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.
2. Татварын байгууллагад төлөх ёстой бүх төрлийн татвараа хугацаанд нь төлж, татварын ямар нэгэн өргүй ажиллалаа.
3. Компанийн нийт 16 ажилтан ажиллагсадтай 2018 онд байгуулах хөдөлмөрийн гэрээг үргэлжлүүлэн байгуулж, ажиллагсдын ажлыг “Ажилтны үнэлгээний хуудас”-аар сар тутамд дүгнэж хэвшлээ.
4. Манай компани нь үүсгэн байгуулагдсаны 15 жилийн ойг тохиолдуулан компанидаа тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан 2 ажилтанд орон сууц худалдан авахад нь зориулж тус бүр 15.0 сая төгрөгний буцалтгүй тусламжийг олголоо.
5. 2018 оны батлагдсан хөрөнгө оруулалтын төсвийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд :
 - Худалдааны төвийн “Б” корпусын дээвэрт агаар сорох 8 ширхэг салхин сэнс буюу диффлекторыг, 1, 2-р давхруудад агаар өгөх 4 ширхэг сэнсийг угсарч суурилуулав.
 - Худалдааны төвийн “Б” корпусын гадна саравчнуудыг шинэчлэн засварлав.
 - Худалдааны төвийн “Б” корпусын дээвэр, гадна фасадыг будах ажлыг хийж байна.
 - Худалдааны төвийн “А” корпусын 1, 2-р давхар, “Б” корпусын 1, 2, С давхруудад мэдээллийн самбарыг шинээр байршуулав.
6. Худалдааны төвийн нийт түрээслэгчидтэй 2018 онд байгуулах түрээсийн гэрээг шинэчлэн байгуулж, тэдгээрийг даатгалд бүрэн хамруулав. Худалдааны төвийн түрээслэгч, ажилтан ажиллагсад зориулан
 - 2018 оны 3-р сарын 25-ны өдөр “Баянгол хөгжлийн түлхүүр” НҮТТБ-тэй хамтран түрээслэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, үйлчилгээний соёл стандарт, хувь хүний чадамжийг дээшлүүлэх сургалтыг
 - 2018 оны 3-р сарын 29-ний өдөр Улсын онцгой байдлаас орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтыг
 - 2018 оны 3-р сарын 30-ны өдөр БГД-ийн Хүүхэд залуучуудын соёлын ордон, Жудо фитнес клубтэй хамтран “Эрүүл монгол” аяны хүрээнд “Идэвхитэй хөдөлгөөн амьдралын хүч” биеийн тамирын дасгал хөдөлгөөний сургалтыг тус тус явуулсан болно.
7. Түрээслэгчдэд сар бүр тогтмол албан захидлаар захиргаанаас гаргаж байгаа мэдээ, мэдээллийг хүргүүлж байна.

8. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит хурлыг 2018 оны 03-р сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Хурлын материалыг холбогдох хууль, журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлсэн. Хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашгийг компани дээр бэлнээр болон Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан бүрэн тараасан.
9. “Би Ди Сек” болон бусад брокерын компаниас тавьсан хүсэлтийн дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааг танилцуулах уулзалтыг тухай бүр нь хийж байна.
10. Компанийн веб сайт болон Монголын хөрөнгийн биржийн сайтаар дамжуулан компанийн тухай мэдээ мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд нээлттэй, ил тодоор мэдээлж байна.